

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-11</i>

-
- 1. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*
- 6-11*

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 12 дугаар сарын 01-ний өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 20 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Жаргалмаа;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, М.Оюунчимэг, Ж.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлогын зохицуулалтын газрын дарга Э.Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Д.Авирмэд, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Л.Батмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын эрх, үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2023 оны 12 сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Н.Энхболд: 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо” /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/,” гэж 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4, 5, 6 дахь дэд заалт тус тус нэмэх:

3.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцын байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо

шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4.Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5.Хот байгуулалтын тухай хуулийн 9.4-т заасны дагуу аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх тохиолдолд ерөнхий архитекторын албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулах;

6.Үл хөдлөх хөрөнгө эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.3-т заасан журамд нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллийг орон сууцжуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг хамаарахгүй талаар тусгах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

4.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: 1.Байнгын хорооны саналаар, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “удирдах” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Н.Энхболд: 1.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “удирдах” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Н.Энхболд: 1.Байнгын хорооны саналаар, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг болон 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.2.4 дэх заалтын “аймаг” гэснийг тус тус хасаж, 2 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн 19.1.6” гэснийг “23 дугаар зүйлийн 23.2.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Н.Энхболд: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг болон 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.2.4 дэх заалтын “аймаг” гэснийг тус тус хасаж, 2 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн 19.1.6” гэснийг “23 дугаар зүйлийн 23.2.6” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Нийслэл, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Нийслэл, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг нийслэл, дүүргийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Энхболд: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийг цахим платформд бүртгэлтэй зорчигч тээвэрлэдэг иргэн хамаарахгүй байхаар зохицуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн ирж, 57.8 хувийн ирцтэйгээр 10 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр,
Баасан гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим, 10 цаг 20 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 12 сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Засгийн газар энэ хуулийн төслийг 2023 оны 10 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх асуудалтай холбоотой санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Өчигдөр чуулганы хуралдаанаар хэлэлцээд зарим асуудлууд дээр тодруулах шаардлага гарсан. Эцсийн хэлэлцүүлгийнхээ үеэр түүнийгээ чиглэл өгсөн асуудлуудаа нэг мөр болгоод ороод ирээрэй гэсэн даалгавартай байгаа. Ажлын хэсэг ажилласан. Ажлын хэсгийн

танилцуулгыг сонсьё. Ер нь бол тараачихсан байгаа. Амартүвшин гишүүн танилцуулчихъя. Амартүвшин гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Амартүвшин: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар 3 зарчмын зөрүүтэй саналыг тус тус боловсрууллаа. Түүнчлэн ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг

төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлд дээр дурдсан зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн төсөл зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Танилцуулгатай холбогдуулаад асуулт асуух хүн байна уу. Алга байна. Тэгвэл зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана.

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаар. 2 санал байгаа.

Энэ 2 саналыг хураахын тулд дэгийн тухай хуулийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн санал хураана.

1.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын эрх, үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.” гэж заасан байгаа.

Санал хурааж эхлэхээс өмнө би ажлын хэсгийг танилцуулаадахъя.

Зам, тээврийн хөгжлийн яамны Автомтээврийн бодлогын зохицуулалтын газрын дарга Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Цолмон, Газар зүй, зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хууль, хяналт шинжилгээний үнэлгээний хэлтсийн дарга Энхтуяа, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ичинноров, Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга Ганхүү, Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Хан-Уул, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Авирмэд, Нийслэлийн орон сууцын корпорац компанийн гүйцэтгэх захирал Говьсайхан, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж улсын тооцоот үйлдвэрийн газрын Гэрээ, эрх зүйн газрын мэргэжилтэн Уранбилэг гэсэн ийм хүмүүс орж байна.

Саяын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 6 гишүүн дэмжиж 60 хувиар энэ санал дэмжигдэж байна.

2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.Энэ хуулийг 2023 оны 12 сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо.

Энийгээ хотынхонтойгоо тохирсон байгаа биз. Тийм ээ. Санал хураалт 70 хувийн саналаар дэмжигдэж байна.

2.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.” Төрийн байгуулалтын байнгын хорооны санал. Санал хураалт.

Энэ дээр чинь тэр засаг дарга өөрөө бас хариуцлага хүлээнэ гэсэн үг нь орохгүй байсан юм уу.

Гишүүдийн 70 хувь нь дэмжлээ энэ саналыг.

Дараагийн санал. Одоо “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар саналууд хураана.

1.Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо” /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/, гэж 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4, 5, 6 дахь дэд заалт тус тус нэмэх:

3.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцын байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар

зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцын байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4.Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5.Хот байгуулалтын тухай хуулийн 9.4-д заасны дагуу аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх тохиолдолд ерөнхий архитекторын албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалд хамааруулсан холбогдох шийдвэрт өөрчлөлт оруулах;

6.Үл хөдлөх хөрөнгө эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6.3-д заасан журамд нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Хот байгуулалтын тухай хуулийн 12.6.3, 12.8-д заасан шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг хамааруулах талаар тусгах.” Төрийн байгуулалтын байнгын хорооны санал. Саналыг дэмжье. Санал хураалт. 7 гишүүн дэмжиж, санал дэмжигдэж байна.

Одоо Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр саналууд тараагдана.

Энийг 42.2.3 дахь заалтыг үндэслэн хураана. Тэгэхээр 1 дүгээр заалт нь ийм заалт байгаа.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “удирдах” гэснийг хассугай.” гэсэн заалт байгаа. Энэ заалтыг 3/2-ын саналаар санал хурааж оруулах нь зүйтэй гэсэн горимын саналаар санал хурааа. Горимын санал. Пүүжээ 7-ын 3/2 явлаа шүү. Санал хураалт. Хөөе минийх яачхав. Болчихсон байна. Горимын санал дэмжигдлээ. Одоо зарчмын зөрүүтэй санал буюу 4 дүгээр зүйл нэмэх:

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “удирдах” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжих санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 70 хувь нь дэмжиж, санал хураалтаар энэ санал дэмжигдлээ.

2 дугаарт. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 2 санал байгаа.

Энийг бас 42.2.3-ын дагуу 3/2-оор хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын саналаар санал хураалт. Санал хураалт. 70 хувийн саналаар гишүүд горимын саналыг дэмжлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг болон 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.2.4 дэх заалтын “аймаг” гэснийг тус тус хасаж, 2 дугаар зүйлийн “19 дүгээр зүйлийн 19.1.6” гэснийг “23 дугаар зүйлийн 23.2.6” гэж өөрчлөх. Төрийн байгуулалтын байнгын хорооны саналыг дэмжих санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 хувийн саналаар дэмжигдэж байна.

2 дугаар санал. Төсөлд дор дурдсан агуулгатай зүйл нэмэх 5 дугаар зүйл энэ чинь бас тусдаа хураах нөгөө горимын саналаараа 3/2-оор энэ асуудлыг хэлэлцье гэдэг горимын саналаар санал

хураалт явуулъя. Санал хураалт. Горимын санал 70 хувиар дэмжигдсэн учраас төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

5 дугаар зүйл.Нийслэл, дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрыг эзэмших, ашиглахаар гаргасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг нийслэл,дүүргийн Засаг дарга газрын тухай хуулийн 33.1, 44.8, 44¹.5-д заасны дагуу шийдвэрлэнэ. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. 70 хувийн саналаар дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсгээс оруулж ирсэн өчигдөр Улсын Их Хурлаас чиглэл авсан дахиж санал хураах шаардлагатай саналуудаар санал хурааж дууслаа. Пүрэвдорж гишүүн 1 санал гаргаад байгаа. Тэр дэгийн дагуу бид нар хэлэлцэж болох нь уу, үгүй юу тайлбарыг нь албан ёсоор Тамгын газар, ажлын хэсэг хариу өгнө. Хурааж болно гэвэл ингээд хураагаад явна. Дэгээрээ тэр саналыг хурааж болж байна уу гэдэг тайлбарыг микрофонд ирээд хэлээдэх. Энэ уг нь ийм санал байгаа юм.

Пүрэвдорж гишүүн юу ч гэсэн зарчмын зөрүүтэй саналаа уничих.

Б.Пүрэвдорж: Энэ Зөрчлийн тухай хууль энэ хуулийг дагалдаж орж ирсэн. Бүртгэлгүй тээврийн хэрэгслээр такси үйлчилгээ эрхлэх юм бол бүр 5 сая төгрөгөөр торгохоор, зөвшөөрөлгүйгээр тэгэхээр энэ тохиолдолд энэ хууль дээр чинь бас дахиад такси үйлчилгээ эрхлэхэд авто тээврийн хуулийн 15.9, 15.10-аар нөхцөл шаардлага хангасан байна гэж байгаа. Тэгээд такси үйлчилгээний зорчигч тээвэрлэх дүрэм холбогдох журмыг хангасан тээвэрлэгч байна гэж байгаа. Энэ бүхэн дээр чинь голицуу ямар байна гэхээр шар дугаартай, симпортой гэхэд л 200 автомашин байгаа. Гэтэл энэ такси үйлчилгээг яаж эрхлэх юм. Тийм учраас энэ дээр би тодорхой санал гаргаж байгаа. Тэгээд

үүгээр бол яах вэ гэхээр шаардлага хангаагүй гээд л нөгөө цагдаа чинь нөгөө хүнийг зорчигч авч явсан гээд л 5 сая төгрөгөөр торгоод унах нь байна шүү дээ. Өөрөөр хэлбэл бид нар энд хууль баталдаг. Гэтэл доор очоод тэнд хуулийн хэрэгжилт ямар шатад байдаг билээ. Хууль дагасан хүнд сурталтай журмууд яаж гардаг билээ та нар бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд зөрчлийн тухай хуулийн 6.30.4 дэх хэсэгт доор дурдсан тайлбар нэмэх:

Тайлбар: Цахим платформоор дамжин бүртгэлтэйгээр зорчигч тээвэрлэдэг иргэн үүнд хамаарахгүй. Тэгэхдээ өчигдөр би яг энэ агуулгаар хотын дарга буюу хууль санаачлагчаас асуусан. Тэгэхээр энэ асуудал дээр бол энэ хуульд бол энэ огт хамаарахгүй гэж хэлж байгаа. Гэхдээ бид нар мэдээж энэ асуултад хариулсан Нямбаатар яваад өгч болно. Энэ хууль чинь хэдэн жил үргэлжилнэ, хэрэгжинэ. Тэгээд энэ үед нь тэгээд тэнд нь, нэг өөр журам гаргаад, тэр хүмүүсээ тэр бизнесээс нь салгах ийм нөхцөл байдал руу орж магадгүй л гэж би үзээд байгаа байхгүй юу даа. Тийм учраас энэ дээр бас яах вэ санал хураалгаж болохгүй гэж хэлэх байх. Би мэдэж байна. Тэгэхдээ 40.1-ээр болно шүү. Яагаад гэвэл энэ чинь анхдагч болон шинэчилсэн найруулга.

Н.Энхболд: Ажлын хэсгийн дарга ямар байр суурьтай байна. Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Хотын дарга бол тэр цахим платформоор бүртгэгдээд явж байгаа хүмүүст хамаарахгүй гэж хэлсэн юм байна. Албан ёсоор. Пүрэвдорж гишүүн болохоор журамдаа тэгж орсон ч гэсэн хуульд тэр үгээр нь заахгүй бол хэзээ нэгэн цагт тэр хүмүүсийг зөвшөөрөлгүй явж байна гээд торгоод байна гэж ингэж үзэж байгаа юм байна. Амартүвшин гишүүний микрофон.

Г.Амартүвшин: Пүрэвдорж гишүүний зарчмын зөрүүтэй саналыг оруулахад бол татгалзах зүйл байхгүй. Ер нь бол хуулиараа тэр нөгөө цахим платформд бүртгэгдсэн жолооч нар бол энэ хуульд хамрагдахгүй байгаа юм. Тэр такси үйлчилгээ зөвшөөрөлтэй такси үйлчилгээ биш учир. Гэхдээ бид нар тэгж ойлгож байгаа болохоос амьдрал дээрээ энэ хууль хэрэгжихдээ бас нугалаа үүсэж магадгүй гэсэн болгоомжлол Пүрэвдорж гишүүн яриад байна л даа. Тэгээд тэрийг бол логикийн хувьд бол бас хүлээн зөвшөөрч байгаа.

Н.Энхболд: Логикийн хувьд бол зарчмын хувьд болно гэж үзэж байгаа юм байна. Дэг талаасаа яаж байгаа юм. Бид нар чинь бас асуудалд ормооргүй байна л даа. Дэг дээрээ тайлбарлаад өгчих. Эсвэл ингэж болно Пүүжээ гишүүнээ. Энэ хууль ингээд гарчихъя. Мааш яаралтай дахиад тусгайлан ганцхан заалт тэрэнд хийе гэж байгаад цохиулаад явуулчхаж болно. Микрофондоо ярь.

Пүрэвдорж гишүүн ээ, дэгээрээ бол болохгүй юм байна. Гэхдээ хуульд хэдүүлээ тогтоол дотор Засгийн газарт өгч байгаа чиглэл дотроо 7 дугаар заалт болгож нэмж оруулаад ийм байдлаар зохицуулах хэрэгтэй гэдгийг нь заагаад оруулчихъя тэгэх үү. Тэгэхдээ биччихсэн байна. Иргэн үүнд хамаарахгүй гээд. Дахиад юу яачих тэр тоо хуулийнхаа юмыг биччихээрэй. Санаа нь бол цахим платформоор дэмжин бүртгэлтэйгээр зорчигч тээвэрлэдэг иргэн гээд энэ дээр нь хуулийнх нь заалтыг бичээд үүнд хамаарахгүй ээ. Зөрчлийн тухай хуулийн 6.30.4 дэх хэсэгт гэдгийг нь дурдаж байгаад “Засгийн газарт чиглэл өгөх” тогтоолд оруулья гэсэн саналыг дэмжиж байна. Санал хураалт. Гишүүдийн 70 хувь нь зөвшөөрлөө. Ингээд боллоо.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон

*сууцжуулах тухай мөн дагалдаж орж
ирсэн бусад хуулиудын эцсийн хэлэлц
хэлэлцүүлгийг хийж дууслаа.*

*Танилцуулгыг Сарангэрэл гишүүн
нэгдсэн хуралдаанд танилцуулна.*

*Хэлэлцэх асуудлаа дууслаа.
Гишүүддээ баярлалаа. Хуралдаан
хаасныг мэдэгдье ээ.*

10.43 цаг.

***Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ***

Э.СУВД-ЭРДЭНЭ